

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

2025 оны жилийн эцсийн
үйл ажиллагааны бичмэл тайлан

Улаанбаатар хот
2025 он




АГУУЛГА:

- 1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**
- 2. САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ**
- 3. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ**
- 4. ХАМРАЛТ, ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТ**
- 5. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА**
- 6. ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛ**

1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1. Хүний нөөц

Тус газар нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/238 дугаар тушаалаар батлагдсан бүтэц, зохион байгуулалтаар нийт 58 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулахаас 57 байцаагч, ажилтантай үйл ажиллагаагаа явуулж, сар бүр орон тооны мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт тайлагнаж ажилласан.




Мөн газрын хүний нөөцийн үндсэн болон цалин хөлсний мэдээллүүд, шилжилт хөдөлгөөнийг МУ-ын Төрийн албаны зөвлөлийн ХНУМТ цахим систем, байгууллагын удирдлагын цогц программ хангамж болох ЭЙБЛ, Нийслэлийн захиргааны байгууллагуудын UBERP цахим систем, Нийгмийн даатгалын салбарын GREEN ERP системүүдэд тухай бүр хийж байцаагч, ажилтнуудын албан хэрэг хөтлөх, цалин хөлс авах, хянах боломжуудыг ханган ажиллаж байна.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Түүнчлэн Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хуулийн дагуу хэрэгжүүлэн, хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг хангах чиглэлийг удирдлага болгон ажиллаж байна.

2025 оны байдлаар 5 гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлд хүргүүлж ажилласан.

Тус газрын албан хаагчдын нийгмийн даатгалын улсын байцаагч, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, төрийн захиргааны албан хаагчид олгох зэрэг дэвийн нэмэгдэл болон бусад судалгааг холбогдох хууль тогтоомжийн дагуу гарган НДЕГ-т хүргүүлэн ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар ГБХНХ-ын сайдын А/16, А/137 тушаалын дагуу төрийн захиргааны 15 албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон.



Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах дотоод ажлын талаар

Нийгмийн даатгалын багц хууль (шинэчилсэн найруулга)-ийг хэрэгжүүлэх, мөн бусад үйл ажиллагаатай холбоотой нийт UB ERP, E-Дос программаар 1373 албан бичиг, ЭЙБЛ программаар 560, шуудангаар 322 албан бичиг, зөвлөмж, чиглэл шинээр батлагдсан дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийг хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Дотоод ажлын хуваарийг боловсруулан баталж цаг үеийн холбогдолтой дээд газраас ирүүлсэн судалгаа, тайлан мэдээг цаг тухай бүрд нь шуурхай хүргүүлж ажиллахаар албан хаагчдыг багийн зохион байгуулалтад оруулан ажиллаж байна.


Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал бүр гарган холбогдох газарт хүргүүлэн ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар:

Нийт 559 өргөдөл гомдлыг хүлээн авснаас:

- Хугацаанд нь шийдвэрлэсэн 538,
- Судлагдаж байгаа 20,
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 1.
- Шийдвэрлэлтийн дундаж хугацааны индекс 0.94 байна.

Ирсэн хэлбэр:



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Агуулга:




Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулсан талаар

НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам” батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн “Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт” батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөн ажиллаж байна.

Тус газраар үйлчлүүлж буй иргэд даатгуулагчдад тав тухтай үйлчлүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор иргэдийн үүдний хүлээлгийн танхимын хэсгийг засаж тохижуулан тусгай хэрэгцээт иргэдэд чиглүүлэх зам, хонх, ариун цэврийн өрөө, тусгай үйлчлэх цонх, мэдээллээр хангах дэлгэц байршуулснаар иргэд даатгуулагчдыг тав тухтай үйлчлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн.




БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН



2. САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

2025 оны жилийн эцсийн байдлаар газрын үйл ажиллагааны зардалд 2,134.1 сая төгрөг батлагдаж ирснээс 2,086.3 сая төгрөгийн зардлыг ангиллын дагуу зарцуулсан ба хэмнэлтийн тухай хуулийн дагуу 47.7 сая төгрөгийг хэмнэж ажилласан. Үүнд:



Сангийн зардалд:

Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төлөвлөгөө 468,555.3 сая төгрөгөөс 469,660.54 сая төгрөгийн зарлагыг батлагдсан төсөвт багтаан сан тус бүрээр зориулалтын дагуу хэтрүүлэлгүй ажилласан. (Нийгмийн даатгалын сангийн зарлага сан тус бүрээр)

	Сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Хэтрэлт-Хэмнэлт+
	Тэтгэврийн даатгалын сан	422,463.3	420,873.6	99.62	1,589.7
	Тэтгэмжийн даатгалын сан	24,167.4	25,275.34	104.6	-1,107.94
	ҮОМШӨ-ний даатгалын сан	3,298.5	2,678.6	81.2	619.9
	Ажилгүйдлийн даатгалын сан	18,613.6	20,822.20	111.9	2,208.6
	Ажил олгогч, даатгуулагч олон нийтэд чиглэсэн сурталчилгаа зөвлөн туслах үйлчилгээ	12.4	10.8	87	1.6
	Нийт	468,555.3	469,660.54	484.32	-1105.34

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Тус газар нь тайлант онд Хаан, Капитрон, Худалдаа хөгжил, Голомт, Төрийн банкуудтай байгуулсан хамтран ажиллах ерөнхий гэрээний дагуу хэрэгжилтийг ханган ажилласан. 2025 оны жилийн эцсийн тэтгэвэр олголтын файлыг сарын ажлын сүүлийн өдрийн харилцагч банкнуудад цахимаар хүргүүлэн файл хүлээлцсэн акт үйлдэж сар бүрийн 01-нд тэтгэврийг олгож байна.

ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО, ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ (САЯ ТӨГРӨГӨӨР)

Тэтгэврийн төрөл	2024 он		2025 он	
	Хүний тоо	Зарцуулсан мөнгө	Хүний тоо	Зарцуулсан мөнгө
 Өндөр насны	27728	298,691.9₮	31213	358,122.8₮
 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	3980	27,757.3₮	4160	25,115.9₮
 Тэжээгчээ алдсаны	1187	8,524.0₮	1309	7,848.1₮
 Цэргийн	1906	30,844.8₮	2117	29,786.6₮
 Нийт	34801	365,818.2₮	38799	420,873.6₮

ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН

Тэтгэмжийн даатгалын сангаас **11323** даатгуулагчдад **25,275.34** сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж олгов. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад **2,321.56** сая төгрөгөөр өссөн байна.

ТЭТГЭМЖ АВАГЧДЫН ТОО, ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ (САЯ ТӨГРӨГӨӨР)

Тэтгэмжийн төрөл	2024 он		2025 он	
	Хүний тоо	Зарцуулсан мөнгө	Хүний тоо	Зарцуулсан мөнгө
 Жирэмсний болон амаржсаны	2,555	16,093.08	2,271	17,614.11
 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	8,417	5,076.70	8,158	5,863.23
 Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж	885	1,784.0	894	1,798.0
 Нийт	11857	22,953.78	11323	25,275.34

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САН

ҮОМШӨ-ний даатгалын сангаас 499 тэтгэвэр, тэтгэмж авагчдад нийт 2678.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨР АВАГЧДЫН ТОО, ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ (САЯ ТӨГРӨГӨӨР)

Тэтгэмжийн төрөл	2024 он		2025 он	
	Хүний тоо	Зарцуулсан мөнгө	Хүний тоо	Зарцуулсан мөнгө
 ҮОМШӨ-ий тэтгэвэр	153	2070.9	179	2264.3
 ҮОМШӨ-ий тэтгэмж, төлбөр	131	373.8	195	340.2
 ХЧАлдсан иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэл	153	82.4	125	74.1
 Нийт	437	2527.1	499	2678.6

АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН

Ажилгүйдлийн даатгалын сангаас 4312 даатгуулагчид ажлаас халагдсаны тэтгэмжид 20822.20 сая төгрөг зарцуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3121.94 сая төгрөгөөр өссөн байна. НДЕГ-ын БХТГазарт албан бичгээр тооцоолол хүргүүлсэн.

ТЭТГЭМЖ АВАГЧДЫН ТОО, ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ (САЯ ТӨГРӨГӨӨР)

Тэтгэмжийн төрөл	2024 он		2025 он	
	Хүний тоо	Зарцуулсан мөнгө	Хүний тоо	Зарцуулсан мөнгө
 Ажилгүйдлийн тэтгэмж	4,716	17,700.26	4,312	20,822.20
 Нийт	437	2527.1	499	2678.6

Тайлан мэдээ:

1.Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цагалбарын дагуу Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн мэдээ тайлангуудыг тус тус боловсруулан хугацаанд нь НДЕГ-ын СБХОГазарт тайлагнан ажилласан.

Мөн сангийн хамрагдалт, орлого, зарлагын мэдээг сарын бүрийн 05-ны дотор дүүргийн Засаг даргын Тамгын газрын Статистикийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

2.Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2023 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Өмч хөрөнгө, эд аж ахуйн тооллого явуулах журам”, газрын даргын А/06 тушаалыг үндэслэн тус газрын эд хөрөнгө , бараа материалын 2025 оны хагас болон бүтэн жилээр тооллогыг зохион байгуулж эд хөрөнгө, бараа материалын дутагдал байхгүй тайланг Нийгмийн даатгалын Ерөнхий газарт хүргүүлэхээр ажиллаж байна.

3.Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны №01/767, 10 дугаар сарын 22-ны өдрийн №814 тоот албан бичгүүдээр хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглах хугацаа сунгах, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

3.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн №01/767 албан бичгийн дагуу тус газарт хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглах хугацаа сунгах, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Үүнд:

- 14 нэр төрлийн 60,485.1 мянган төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмж 5ш,
- Тавилга эд хогшил 6ш,
- Бусад хөрөнгө 2ш,
- Нийтийн эзэмшлийн 1ш хөрөнгүүдийг актлуулах саналыг хүргүүлсэн.

НДЕГ-ын даргын 2025.11.07-ны өдрийн А/309 дүгээр тушаалаар олгосон шинэ тоног төхөөрөмжүүдийг байгууллагын данс тооцоонд бүртгэн авсан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгө акталж данснаас хасах тухай шийдвэрээр 14 нэр төрлийн 34.3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлээс хасаж устгалд орууллаа.

4.Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээний дагуу ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын олон төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжийг олгох, мөн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйлгээг шуурхай чирэгдэлгүй гүйцэтгэх зарчмыг баримтлан ажилласан.

Мөн тэтгэвэр тэтгэмж олгох, сангийн дансны үлдэгдлийг төвлөрүүлэх зэрэг олон ажлуудыг гэрээнд дурьдсан журмын дагуу хийж гүйцэтгэсэн.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Нийгмийн даатгалын газрын хэмжээнд төрийн сан болон арилжааны таван банкинд байршиж буй нийт 23 дансаар гүйлгээ хийгдэж, хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж, биелэлтийг НДЕГ-ын СБХОГазарт хугацаанд нь хүргүүлэхээр ажиллаж байна.

Бусад ажил:

- 2025 оны нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны санхүүгийн тайланд Гэрэлтэх бүртгэл аудит ХХК аудитын шалгалт хийгдэж байна.
- Түүнчлэн 2024 оны сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжөөр 4-5 жилийн насжилттай 33 харилцагчаас авах 159,349.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бүрэн барагдуулан 11 жилийн насжилттай ажилласан жил тооцох нөхөн даатгалын шимтгэлийн 203 хүнд өгөх 2,339.3 мянган төгрөгийн өглөгийг тодруулан буцаан олгох анхан шатны бүрдлийг ханган ажиллаж 99.8 хувийн биелэлттэй байна.
- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 203,614.0 төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүйг нөхөн мэдээллэж, ХХОАТ-ын 437.6 мянган төгрөгийн, НДШ-ийн 94.4 мянган төгрөгийн, нийт 532.0 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулан, ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан. 2025 оны байдлаар үйл ажиллагааны орлого, зардлын шилэн дансны мэдээллийг цахим системд тухай бүр, хуулийн хугацаанд тайлагнаж байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 70 мэдээллийг байгууллагын нягтлан бодогч, нийгмийн даатгалын сангийн 77 мэдээллийн 14 төрлийн 14,874 ширхэг мэдээллийг сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтнүүд <https://info.shilendans.gov.mn> сайтад 7 хоног, сар, улирал, жилээр мэдээллийг байршуулж ахлах нягтлан бодогч болон газрын даргын тушаалаар хяналт шалгалтын байцаагч байнгын хяналт тавин ажиллаж байна.

№	Тайлангийн өр	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах өгүүлэл	Тайлан оруулах хэрэгжлэгч	Зөвөлж эж	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Хэрэглэлийн мэдээллийн хивцэл																	
Нийт мэдээлэл: 171						Хугацаанд Мэдээлсэн: 69						Хугацаа хооронд Мэдээлсэн: 1					
Төрийн байгууллага																	
Тайланг өгө: 2025																	
Сар бүр																	
1	Төрийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэрэгт хэмжээний шалтгаан тайлбарын хамт зөвхөн засгийн ажиллагаа	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	БАТМӨНХ ЧАНЦАЛ	*	✓	✓	✓	✓	✓	○	○	○	○	○	○	○
2	Төрийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл - Халивбар, зориулалт	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	БАТМӨНХ ЧАНЦАЛ	*	✓	✓	✓	✓	✓	○	○	○	○	○	○	○
3	Харенгийн зардал, харангө оруулалтын төсөв, арга хэмжээний гүйцэтгэл, хөндсөнхэн зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	БАТМӨНХ ЧАНЦАЛ	*	✓	✓	✓	✓	✓	○	○	○	○	○	○	○
4	Байгууллагын батлагдсан орон тооноос өөрөөр өөрчлөлт	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	БАТМӨНХ ЧАНЦАЛ	*	✓	✓	✓	✓	✓	○	○	○	○	○	○	○
Хягас жил бүр																	
5	Санхүүгийн тайлан	Гүйцэтгэл	хягас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор	БАТМӨНХ ЧАНЦАЛ	*						○						
6	Ханди, тусламжийн орлого	Гүйцэтгэл	хягас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор	БАТМӨНХ ЧАНЦАЛ	*						○						
7	Ханди, тусламжийн зарцуулалтын тайлан	Гүйцэтгэл	хягас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор	БАТМӨНХ ЧАНЦАЛ	*						○						
8	Өмнөх оны төсвийн зарлагын хэмжээг, туслам үйл ажиллагааны орлогоос давсан	Гүйцэтгэл	хягас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор	БАТМӨНХ ЧАНЦАЛ	*						○						

3. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Ажилгүйдлийн тэтгэмжийн тогтоолт, олголт, дотоодын хяналт шалгалт хийсэн ажлын талаар

Нийгмийн даатгалын ерөнхий хууль нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон Газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн “Дотоодын хяналтыг сайжруулах” А/10 тоот тушаалын дагуу ажилгүйдлийн тэтгэмжийн тогтоолт, олголт, дотоодын хяналт шалгалтыг хийсэн. Нийт 6 үзүүлэлтийн дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.

2023-2024 онд олгосон ажилгүйдлийн тэтгэмжийн дүн			
2023 он		2024 он	
Тэтгэмж авсан даатгуулагчийн тоо	Олгосон дүн	Тэтгэмж авсан даатгуулагчийн тоо	Олгосон дүн
3957	15 тэрбум	4320	17,7 тэрбум

2023 онд 3957 даатгуулагчид 15,041,722,757.76 тэрбум, 2024 онд 4320 даатгуулагчид 17,700,258,218.26 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг тогтоож олгосон байна. Шалгалтаар 2023 онд 850 даатгуулагчид, 2024 онд 4311 даатгуулагчид олгосон ажилгүйдлийн тэтгэмжийн тогтоолт, олголтыг мэдээллийн сан болон анхан шатны баримт материалд үндэслэн шүүж үзэхэд 2023 онд 301 даатгуулагч, 2024 онд 421 даатгуулагчид илүү олгосон байх магадлалтай зөрчил илэрсэн тул ажилд орсон, гарсан тушаалын хуулбар болон санхүүгийн баримттай тулган баталгаажуулсан.

Төлбөр зөрчлийн дүн

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль”- ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэхь заалтыг зөрчиж 51 даатгуулагчид 86,038,791.46 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж илүү олгосон зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Улсын байцаагчийн “250256” тоот акт тогтоож шийдвэрлэсэн. Улсын байцаагчийн тогтоосон актын төлбөрөөс 2025 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн байдлаар 30 хүний 41,338,347.04 төгрөгийг барагдуулан ажилласан. 2024 онд Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн зөрчилтэй байх магадлалтай 340 даатгуулагчийн тушаалын хуулбарыг авч нягтлах ажил хийгдэж байна. 2023 онд Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн зөрчилтэй байх магадлалтай 301 даатгуулагчийн ажилд орсон тушаалыг авч зөрүү тооцох үүрэг даалгаврыг Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэст хүргүүлж ажилласан.

Тэтгэврийн хувийн хэргийн тооллого хийж, олголт шалгасан ажлын талаар

Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 20-ний өдрийн №01 тоот “Тэтгэврийн хувийн хэргийн тооллого хийж, олголт шалгах” удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль тэдгээрийг хэрэгжүүлэх талаар гаргасан тогтоол, шийдвэр, журам, дээд газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмж болон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан.

Тэтгэврийн хувийн хэргийн тооллого хийж, олголт шалгах ажлын хүрээнд нийт 36005 тэтгэврийн хувийн хэрэг тоологдохоос 35993 тоологдож, 12 хувийн хэрэг дутуу бүртгэлтэй байсаныг шалгалтын хугацаанд олж тооллогод хамруулах ажлыг зохион байгуулсан.

Тооллогын дүн

Нийт	2024 оны хуучин тогтоолт	2025 оны шинэ тогтоолт	Тооллогод хамрагдсан
36005	33594	2411	36005

Олголт шалгасан ажлын талаар

2024 онд шилжиж явсан, нас барсан, зогсоогдсон тэтгэвэр авагчдын тоо		
Шилжиж явсан	Нас барсан	Зогсоогдсон
154	541	1127

Олголтаар илэрсэн төлбөр зөрчлийн дүн

2024 онд шилжиж явсан, нас барсан, зогсоогдсон тэтгэвэр авагчдад илүү олгосон төлбөр зөрчлийн дүн					
Нас барсан		Зогсоогдсон		Шилжиж явсан	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
16	30572727	12	6611672	5	6604490

Шалгалтаар илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоож барагдуулан ажиллаж байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хяналт шалгалт хийсэн ажлын талаар

Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан “2024 онд ирүүлсэн ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хяналт шалгалт хийх” №05 тоот удирдамжийн дагуу Монгол улсын Нийгмийн даатгалын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 тоот нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам болон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох бусад хууль, тогтоомж, Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан.Тус хэлтэс нь 2024 онд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 90.57 хувиар биелүүлж ажилласан байна. 2024 онд нийт 8258 байгууллагын шимтгэл төлөгч албан журмын даатгалд хамрагдсан байна. Тайлан өгвөл зохих 8258 мянган байгууллагаас 8215 байгууллага НД-ын шимтгэл төлөлтийн тайлан өгсөн бөгөөд тайлан авалтын хувь 98,8 тай байна.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Д/д	Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	2024	547.2	495.6	90.57

Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн ААНБ, Даатгуулагчдын тоо		
	Нэрс	Ажил олгогчийн тоо
1	М.Энхбаяр	907
2	Ц. Чанцал	790
3	Ж.Алтанцэцэг	293
4	Ч.Баатаржав	991
5	Б.Солонго	908
6	Н.Энхболд	867
7	Х.Оюунцэцэг	842
8	Д.Чанцалням	927
9	С.Долгорсүрэн	881
10	Б.Санжаасүрэн	852
	Нийт	8258

Тайлан өгвөл зохих 8258 мянган байгууллага байгаагаас 8215 байгууллага НД-ын шимтгэл төлөлтийн тайлан өгсөн бөгөөд тайлан авалтын хувь 98,8 тай байна.

Шинээр 760 байгууллага шимтгэл төлөгчөөр нэмж бүртгүүлсэн, 26 байгууллага шилжсэн байна. Шинээр 760 байгууллага шимтгэл төлөгчөөр нэмж бүртгүүлсэн, 26 байгууллага шилжсэн байна. Тус хэлтэс нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/99 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах баталгаажуулах журам”-ыг зөрчиж нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанаас хоцроосон албан тушаалтанд “Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хууль”-ийн дагуу шийтгэлийн хуудсаар 2024 онд 5 аж ахуйн нэгжид 1,2 сая төгрөгийн, торгууль ногдуулан хариуцлага тооцон ажилласан байна. 2024 онд 11 ажил олгогч, 19 даатгуулагч цалин өөрчлөх хүсэлт гаргасан байна. 5 даатгуулагчийн цалин устгаж залруулсан байна.

Тайлан авалтын талаар				
Нэрс	Тайлан өгвөл зохих	Тайлан өгсөн	Зөрүү	Тайлан авалтын хувь
М.Энхбаяр	907	901	6	94.2
Ц. Чанцал	790	784	6	99
Ж.Алтанцэцэг	293	288	5	98.2
Ч.Баатаржав	991	985	6	99.3
Б.Солонго	908	903	5	99.7
Н.Энхболд	867	867		100
Х.Оюунцэцэг	842	840	2	99.7
Д.Чанцалням	927	922	5	99.1

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

С.Долгорсүрэн	881	878	3	99.6
Б.Санжаасүрэн	852	847	5	99.4
Нийт	8258	8215	43	98.8

Тайланд хөдөлгөөн хийгдсэн байдал							
	Нэрс	Нийт бүртгэлтэй	Идэвхтэй	Шинээр бүртгүүлсэн	Идэвхгүй	Зогссон, Татан буугдсан	Шилжиж явсан
1	М.Энхбаяр	1253	818	89	346		
2	Ц. Чанцал	1236	790	70	374		2
3	Ж.Алтанцэцэг	548	238	55	255		
4	Ч.Баатаржав	1475	906	85	481	2	1
5	Б.Солонго	1151	813	95	183	58	2
6	Н.Энхболд	1131	775	92	225	36	3
7	Х.Оюунцэцэг	1166	747	94	163	161	1
8	Д.Чанцалням	1361	864	63	418	1	15
9	С.Долгорсүрэн	1250	793	88	367	0	2
10	Б.Санжаасүрэн	1279	823	29	427		
	Нийт	11850	7567	760	3239	258	26

Цалин залруулга				
	Нэрс	Цалин өөрчилсөн А/О	Цалин өөрчилсөн /Даатгуулагчаар/	Цалин устгасан
1	М.Энхбаяр	3		2
2	Ц. Чанцал	2		2
3	Ж.Алтанцэцэг			
4	Ч.Баатаржав	2	2	
5	Б.Солонго		6	1
6	Н.Энхболд			
7	Х.Оюунцэцэг	2	6	
8	Д.Чанцалням	1	4	
9	С.Долгорсүрэн	1	1	
10	Б.Санжаасүрэн			
	Нийт	11	19	5

Төрөл буруу, Кодын зөрчилтэй						
№	Нэрс	Төрөл буруу	01 код давхардсан	Ажил эрхэлдэг тэтгэвэр авагчийн код /22/ төрөл буруу	Хүүхдээ асрах эхийн кодын зөрчилтэй	Сул зогсолтын кодын зөрчилтэй
1	М.Энхбаяр	10	4		6	
2	Ц. Чанцал	19	14	2	3	
3	Ж.Алтанцэцэг	9	3	3	2	1
4	Ч.Баатаржав	18	6	7	5	

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН**

5	Б.Солонго	8	3	3	2	
6	Н.Энхболд	4	2	2		
7	Х.Оюунцэцэг	13	5	5	3	
8	Д.Чанцалням	11	2	4	5	
9	С.Долгорсүрэн	8	3	2	3	
10	Б.Санжаасүрэн	14	5	3	6	
Нийт		114	47	31	35	1

Регистр зассан, нэгтгэсэн			
	Нэрс	РД Зассан	РД нэгтгэсэн
1	М.Энхбаяр		
2	Ц. Чанцал	5	4
3	Ж.Алтанцэцэг	10	4
4	Ч.Баатаржав	3	3
5	Б.Солонго		4
6	Н.Энхболд	7	
7	Х.Оюунцэцэг	6	
8	Д.Чанцалням		8
9	С.Долгорсүрэн	8	
10	Б.Санжаасүрэн	7	7
Нийт		46	30

Шалгалтаар:

НД№7, НД№8 тайланг хэвлэмэл хэлбэрээр хүлээн авахдаа хариуцсан байцаагч хянаж, баталгаажуулсан огноо /он, сар, өдөр/ буюу тайлан ирүүлсэн, хүлээн авсан хугацааг бичдэггүй, ажил олгогч байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал дутуу, даатгуулагчдын ажил мэргэжлийн ангилал дутуу болон буруу, даатгуулагчдын төрөл кодын зөрчилтэй, байцаагчийн тамга тэмдэг, гарын үсгийн тайлал дутуу зэрэг зөрчил нийтлэг байна. Мөн 2023 оны шимтгэл төлөлтийн тайланд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн кодын зөрчлийг арилгаж, авч хэрэгжүүлсэн ажлын тайлан ирүүлэх тухай Улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлэн хариуг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа, хяналтын хэлтэст ирүүлэхийг үүрэг даалгавар болгосон. Шалгалтаар 2024 онд нийгмийн даатгалын шимтгэл төлж тайлан өгсөн аж ахуйн нэгж байгууллагуудын хадгаламжийн нэгжийг архивд хүлээлгэн өгөөгүй зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж авч хэрэгжүүлсэн ажлын тайлан ирүүлэх хугацаатай үүрэг даалгаврыг хүргүүлэн ажилласан.

**Нийгмийн даатгалын сангийн зарцуулалтад тавих дотоодын хяналт
шалгалтыг зохион байгуулсан ажлын талаар**

Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 08/1913 тоот албан бичгийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Шалгалтаар 2021-2024 онд хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон 412 тэтгэвэр авагчийн ажилласан жил эсхүл цалинг тодорхойлсон лавлагааны үндэслэлийг шалгасан.

- 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 06/619, мөн оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 06/742 дугаар албан бичгээр өгсөн шинжээчийн дүгнэлт, тушаалуудын жагсаалтад байгаа тушаалаар тэтгэвэр тогтоосон эсэхэд дотоодын хяналт, шалгалтыг хийх;
- Ажилласан жил эсхүл цалинг тодорхойлсон Архивын ерөнхий газар, Нийслэлийн архивын газар, аймгийн болон төрөлжсөн, тусгай архивын байгууллагаас гаргасан лавлагааны үндэслэлийг тухайн архивын байгууллагад шалгах;
- Хуурамч байх магадлалтай тушаал, архивын лавлагааны үндэслэлийг шалган, шаардлагатай тохиолдолд криминалистикийн шинжилгээ хийлгэх, шинжээчийн дүгнэлт гаргуулах;

2021-2024 онд хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон 412 даатгулагчдын ажилласан жил эсхүл цалинг тодорхойлсон Архивын ерөнхий газар, Нийслэлийн архивын газар, аймгийн болон төрөлжсөн, тусгай архивын байгууллагаас гаргасан лавлагааны үндэслэлийг тухайн архивын байгууллага, ажил олгогчийн архивын баримтыг шалгалаа.

Шалгалтаар архивын лавлагааны үндэслэл нягтлах шаардлагатай 18 тэтгэвэр авагчийн баримтыг шалга

Д/д	Архивын газар	Тэтгэвэр авагч
1	Архивын ерөнхий газар	1
2	Дархан-уул аймгийн Архив	9
3	Увс аймгийн Архив	1
4	Ажил олгогчийн архив	7
5	Нийт	18

**ААНБ-ААС ИРҮҮЛСЭН АЛБАН БИЧИГ, ӨРГӨДЛИЙН ДАГУУ ШАЛГАЖ ШИЙДВЭРЛЭСЭН
АЖЛЫН ТАЛААР**

2025 онд 643 ААНБ-аас ирүүлсэн албан бичиг, өргөдлийг шийдвэрлэн 1,535,718,923 тэрбум төгрөгийн цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос 259,886,472 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, 123,725,429 сая төгрөгийн алданги ногдуулж, нийт 383,611,902 сая төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож төлбөр зөрчлийг 100 хувь барагдуулан ажилласан.

ААНБ-ын тоо	Төлбөр зөрчлийн дүн	Барагдуулсан дүн
643	383,611,902	383,611,902

ААНБ-аас ирүүлсэн албан бичиг, өргөдлийн дагуу шалгаж шийдвэрлэсэн хяналт шалгалт

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ АЖИЛ ОЛГОГЧ
БАЙГУУЛЛАГАД ШАЛГАСАН АЖЛЫН ТАЛААР**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн №01/336 тоот албан бичиг болон аж ахуйн нэгж байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж, Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн №02 тоот удирдамжийн дагуу Их, дээд болон коллежийн, түүнчлэн ерөнхий боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан. Нийт 19 байгууллага шалгалтад хамрагдсан.

Шалгалтаар: 12 байгууллага нь 507,858,033 төгрөгийн цалингийн сангаас нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй зөрчил илэрсэн. Төлөгдөөгүй цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос 115,125,604 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, 53,062,807 төгрөгийн алданги ногдуулсан. Шимтгэл, алданги бүгд нийлээд 168,188,411 төгрөгийн төлбөр зөрчилд улсын байцаагчийн акт тогтоосон. Актаар тогтоосон төлбөрийг 100 хувь бүрэн барагдуулсан. Зөрчил илрээгүй 7 байгууллагад хяналт шалгалтын зөвлөмж өгч ажилласан.

Шалгасан ААНБ-ын тоо	Илэрсэн төлбөр зөрчлийн дүн	Барагдуулалт
12 ААНБ	168,188,411	168,188,411

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛАСАН АЖЛЫН ТАЛААР

1.Зөрчлийн тухай хуулийн 10.17.1, 10.17.2, 10.17.5 дугаар заалтын дагуу хялбаржуулсан журмаар 35 аж ахуй нэгж байгууллагад 22,7 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулж БГД-н Прокурорын нэгдсэн бүртгэлд хугацаанд нь бүртгүүлж торгуулийг бүрэн барагдуулсан.

ААНБ-тоо	Торгуулийн дүн	Барагдуулалт
35	22,7 сая	22,7 сая

ӨР АВЛАГА БАРАГДУУЛАН АЖИЛЛАСАН АЖЛЫН ТАЛААР

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлд заасан ажил олгогч, даатгуулагчийн эрх үүргийг удаа дараа зөрчиж нийгмийн даатгалын шимтгэлээ эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд төлөөгүй 37 аж ахуйн нэгжийн 3,491,633,693.81 (гурван тэрбум дөрвөн зуун ерэн нэгэн сая зургаан зуун гучин гурван мянга зургаан зуун ерэн гурван төгрөг наян нэгэн мөнгө) төгрөгийг барагдуулах чиглэлээр харьяалах дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Тус газраас шүүхэд гаргасан нэхэмжлэлүүдээс 27 аж ахуйн нэгжид холбогдох 6,056,709,312.20 (зургаан тэрбум тавин зургаан сая долоон зуун есөн мянга гурван зуун

арван хоёр төгрөг хорин мөнгө) төгрөгийг барагдуулах нэхэмжлэлтэй иргэний хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Дээрх шийдвэрлэгдсэн иргэний хэргийн шийдвэрүүд албажиж ирснээр байгуулсан гэрээ, тогтоосон хугацаанд 1,696,636,536.30 (нэг тэр бум зургаан зуун ерэн зургаан сая зургаан зуун гучин зургаан мянга таван зуун гучин зургаан төгрөг гучин мөнгө) төгрөгийн төлбөр барагдаж байна. Тухайн аж ахуйн нэгжүүдийн төлбөр төлөлтийн байдлыг сар бүр сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэнтэй дансны тулгалт хийж баталгаажуулж ажиллаж байна.

Шүүхэд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр болон түүнээс үүссэн алдангийг барагдуулах чиглэлээр гаргасан нэхэмжлэлүүдээс 2025 оны эхний 10 сарын байдлаар 5 аж ахуйн нэгжийн 435,624,818.09 (дөрвөн зуун гучин таван сая зургаан зуун хорин дөрвөн мянга найман зуун арван найман төгрөг есөн мөнгө) төлүүлэх шүүхийн шийдвэр гарсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэл болон алдангийн өртэй 11 аж ахуйн нэгжийг үйл ажиллагаа явуулдаг тодорхой хаяггүй үндэслэлээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйл 65.1.9 дэх хэсэгт заасан Хариуцагчийн хаяг тодорхойгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосныг мөн хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.9 дэх хэсэгт заасны дагуу эрэн сурвалжлуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргаж, тухайн хүн, хуулийн этгээдийг эрэн сурвалжлах нэхэмжлэлийг шүүхэд гаргаж захирамж гаргуулснаар Баянгол дүүргийн Цагдаагийн газрын 1, 2-р хэлтэст хүргүүлэн, үйл ажиллагаа явуулдаг хаягыг олж тогтоох ажлыг тус цагдаагийн газар, хэлтсүүдтэй хамтран ажиллаж байна.

Эрэн сурвалжлах шүүгчийн захирамж гарч цагдаагийн байгууллагад хүргэгдсэн захирамжийн хэрэгжилт, биелэлт хангалтгүй, удаашралтай байгаа тул тус газраас 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 1778 дугаартай албан бичгээр, 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 161 дугаартай албан бичгүүдээр тухайн аж ахуйн нэгжийг эрэн сурвалжлах шүүгчийн захирамжийн хэрэгжилт хэрхэн байгаа, эрэн сурвалжлах ажиллагаа ямар шатанд явж байгаа талаарх мэдээлэл авах тухай албан бичгүүдийг хүргүүлж, тухайн газар, хэлтсийн дарга, холбогдох албан тушаалтнуудтай хуулийн мэргэжилтэн уулзаж, харилцан санал солилцон ажилласан.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өр түүнээс үүссэн алдангийг барагдуулах чиглэлээр харьяалах дүүргийн шүүхэд гаргаж нэхэмжлэл хангагдаж шийдвэрдэгдсэнээс өнөөдрийн байдлаар нэр бүхий 24 аж ахуйн нэгжийн 1,899,801,659.40 (нэг тэрбум найман зуун ерэн есөн сая найман зуун нэг мянга зургаан зуун тавин есөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн өр төлбөрийг ажил олгогч, хуулийн этгээд бүрэн төлж барагдуулж байна.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ:

1.Нийгмийн даатгалын ерөнхий газраас Цагдаагийн ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, тухайн гэрээнд шүүхээс даалгасан хүн, хуулийн этгээдийг иргэний журмаар эрэн сурвалжлах ажлыг шуурхай, чанартай, үр дүнтэй зохион байгуулах талаар тусгаж өгөх;

2.Нийгмийн даатгалын байгууллагаас 2025 оны “Даатгуулагчдийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарласантай холбогдуулан насжилт өндөртэй, өр төлбөр ихтэй аж ахуйн нэгжүүдийг шүүхийн байгууллагад шилжүүлэхтэй холбогдуулан бичиг хэргийн зардал, нотариатын зардал ихээр гарч байгаа тул холбогдох төсвийг нэмэгдүүлэх;

3.Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Банкны төлбөр барагдуулах газарт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа иргэний хэргүүдийн төлбөр барагдуулахад онцгой анхаарч, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах

4.Нэхэмжлэгч байгууллагаас нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр, түүнээс үүссэн алдангийг барагдуулах чиглэлээр нэхэмжилж байгаа нэхэмжлэлд хавсаргах баримтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйл 44.4 дэх хэсэгт заасны дагуу байгууллагын архивын “Хуулбар үнэн” тэмдэг дарсан байдлаар хүлээн авч байхад анхаарах талаар Шүүхийн ерөнхий зөвлөлтэй харилцан тохиролцож шийдвэрлэх, нотариатын зардал өндөр гарч байна.

5.Нийгмийн даатгалын байгууллагаас шаардлагатай мэдээ, мэдээлэл хаяг болон татан буугдсан, дампуурсан эсэх талаарх мэдээллийг УБЕГ-аас болон харьяа дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс гаргаж өгч байхад анхаарч шийдвэрлэх

**Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх
хяналт шалгалт хийсэн ажлын талаар**

Монгол улсын Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 2 дугаар тогтоол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Хяналт шалгалтын объектын жагсаалт батлах тухай А/78 дугаар тушаал, Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны №08-07/06 дугаартай Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу Сонгинохайрхан дүүргийн нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчтай хамтран Сүхбаатар, Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газрын ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт зарцуулалтад хяналт шалгалт хийх ажлыг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Шалгалтаар:

1.Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын газар нь 12 даатгуулагчид 13,672,087 төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж илүү олгосон зөрчил илэрсэн тул 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн илүү олгосон тэтгэмжийг төлүүлэх №СХ32/00008 тоот улсын байцаагчийн акт тогтоосон. Мөн ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон

29 даатгуулагчийн тушаалыг авч зөрүү тооцож буцааж төлүүлэх №СХ32/010 тоот улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

2.Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газар нь 2 даатгуулагчид 2,036,962 төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж илүү олгосон зөрчил илэрсэн тул илүү олгосон тэтгэжийг төлүүлэх 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн №СХ32/00007 тоот улсын байцаагчийн акт тогтоосон. Мөн ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон 78 даатгуулагчийн тушаалыг авч зөрүү тооцож буцааж төлүүлэх №СХ32/011 тоот улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.



АКТ БАРАГДУУЛАЛТ



4. ХАМРАЛТ, ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТ

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарласантай холбогдуулан ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

1. Тус хэлтэст нийт 12218 ажил олгогч бүртгэлтэй байгаагаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 8127 ажил олгогчийн 141,588 даатгуулагчийн мэдээллийг Нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илгээх, хүлээн авах, хянах, баталгаажуулах журам”-ын дагуу хүлээн авч, мэдээллийн баазыг бүрдүүлэн ажиллалаа. 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан авалт 91.95 % байна.

2. 2025 оны 12 дугаар сарын байдлаар албан журмын даатгалд 592,703,379.24 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс 534,025,744.69 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөний биелэлт 90,1 хувьтай байна.



(Орлогын төлөвлөгөө болон биелэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулан графикаар харуулав)

3. 2025 оны жилийн эцсийн тайлангаар 59,469,364.04 мянган төгрөгийн өр авлагатай гарсан бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

- 176 ажил олгогчтой уулзалт зохион байгуулж 71 ажил олгогчийн 6,721,700.0 мянган төгрөгийг,
- 224 ажил олгогч байгууллагатай авлага барагдуулах гэрээ байгуулж 59 ажил олгогчийн 8,561,840.0 мянган төгрөгийг,
- 320 ажил олгогч байгууллагад улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж 223 ажил олгогчийн 12,225,160.00 мянган төгрөгийг,

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

- 3,897 ажил олгогчийн харилцах дансны зарлагын гүйлгээнд барилт хийж 1,904 ажил олгогчийн 22,459,540.0 мянган төгрөгийг,
 - Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжүүлсэн 24 ажил олгогчид гүйцэтгэх ажиллагаа явуулж 1,899,801.66 мянган төгрөгийг тус тус барагдуулсан.
 - 3,491,633.69 мянган төгрөгийн өртэй 37 ажил олгогчийн өрийг барагдуулах чиглэлээр харьяалах дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан.
- Тайлант хугацаанд дээрх ажлуудыг зохион байгуулснаар нийт 51,868,041.66 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг барагдуулсан үзүүлэлттэй байна.

**2025 оны жилийн эцсийн өр, авлагын
барагдуулалтын мэдээ**



Шимтгэлийн авлагыг барагдуулахаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн А/64 дугаар “Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө биелүүлэх, шимтгэлийн авлага барагдуулах тухай” журмын дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй ажил олгогчийн авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, сангийн орлогыг нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

2025 оны эхний өр авлага 59,469,364.04 мянган төгрөгөөс 34,479,122.88 мянган төгрөгийг буюу 58 хувийг барагдуулж ажилласан.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН



Тайлант хугацаанд нийгмийн даатгалд шинээр 875 аж ахуйн нэгж байгууллага, 2410 иргэнийг албан журмын даатгалд хамруулсан.

4. 2025 оны 12 дугаар сарын 03-ны байдлаар 74,274,181.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагатай байна. Өр авлага өссөн шалтгаан нь: Дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас ажил олгогч байгууллагуудын санхүүгийн чадавхи буурсан, үйл ажиллагаа доголдож, сэргэж чадахгүй байгаа, тээвэр, өргөн хэрэглээний барааны үнэ өссөн, барилгын материалын үнэ өсч барилгын үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүд санхүүгийн хүндрэлд орсон, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт хүндэрсэн, доголдсоноос эрүүл мэндийн байгууллагууд болон эм ханган нийлүүлэх байгууллагуудын татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр үүссэн. Улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-уудын үйл ажиллагаа жигдрээгүй. Тухайлбал зам, барилга, уул уурхай гэх мэт.

5. НДЕГ-аас ирүүлсэн судалгааг тухай бүрт нь гарган хүргүүлж ажилласан.

6. <https://erp.ulaanbaatar.mn> программаар ирсэн иргэний 211 өргөдөл, аж ахуйн нэгж байгууллагын 580 албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлээд байна. Ямар нэгэн гомдол, зөрчил гараагүй болно.

7. НДЕГ-т нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, авлагын сарын мэдээг сар бүрийн 01-ний өдөр, авлагатай байгууллагад авсан арга хэмжээний мэдээг сар бүрийн 15-ны өдөр журмын дагуу батлагдсан маягаар хугацаанд нь гарган өгсөн.

8. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/47 тоот тушаалаар батлагдсан даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөний дагуу дэд төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган биелэлтийг тухай бүрт нь гарган ажилласан.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомж, заавар, журам, чиглэлийг байцаагч ажилтнуудад судлуулан мөн дээд газруудаас ирүүлсэн заавар, журам, чиглэлийг нэг мөр хэрэгжүүлэн ажиллаж байна.

“ИТГЭЛЦЛИЙН АЯН”

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “ИТГЭЛЦЛИЙН АЯН” зохион байгуулах тухай 2025 оны А/244 дугаар тушаалын дагуу нийгмийн даатгалын хуримтлагдсан өр авлагыг барагдуулах, иргэд, даатгуулагчдад мэдээлэл хүргэх чиглэлээр төлөвлөгөө гарган 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:


1. Тус аяны хүрээнд Газрын даргын тушаалаар дэд төлөвлөгөө батлуулан ажиллаа.
2. Аяны хугацаанд нийт 75 ажил олгогчийн захирал, санхүүгийн ажилтан, хүний нөөцийн мэргэжилтэнүүдэд тус газрын хурлын танхимд Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах, ажил олгогч даатгуулагчдыг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр танхимаар сургалт зохион байгуулан ажиллаа. Тус сургалтад UBS телевиз аяны мэдээллийг танилцуулан сурталчилан хамтран ажилласан болно. /Хандалтын тоо 4,3К /



3. Нийгмийн даатгалын шимтгэлийн 5,583,020.0 төгрөгийн хуримтлагдсан өртэй 185 ажил олгогчийн гүйцэтгэх захирлуудтай биечлэн болон утсаар, цахимаар мэдээлэл хүргэж, уулзалт зохион байгуулж мөн нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 49 ажил олгогч байгууллагад 2,772,160,000.0 төгрөгийн улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлсэнээс 62,650,000.0 төгрөгийн авлагыг барагдуулан ажиллаа. НДШХУАХ-с ирүүлсэн хуримтлагдсан өртэй ажил олгогчийн жагсаалтаас 1,217 ажил олгогчийн 10,603,804,397.18 төгрөгийн өр авлагыг барагдуулан ажиллаа.
4. Нийт 48 аж ахуйн нэгж байгууллагын 5,931,438,077.14 төгрөгийн шимтгэлийн өрийн дүнгийн 10 доошгүй хувь болох 1,513,564,522.46 төгрөгийг төлүүлж, 6 сар хүртэл хугацаатай өр төлөх хуваарь, гэрээ байгуулан ажиллаж байна.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

5. Аяны хугацаанд ажил олгогч байгууллагын арилжааны банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох мэдэгдлийг нэмж хүргүүлээгүй. Аяны хугацаанаас өмнө дансыг нь хаасан 25 ажил олгогчийн шимтгэлийн өрийн дүнгийн 10 доошгүй хувь 168,729,534.06 төгрөгийг төлүүлж банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоосон шийдвэрийг цуцлан дансыг нээлээ.
6. Ажил олгогч нь шимтгэлийн хуримтлагдсан өрийн дүнгийн 10 доошгүй хувийг төлж гэрээ байгуулсан нийт 38 ажил олгогчийн, 31 даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж, 5 даатгуулагчид жирэмсэн амаржсаны тэтгэмж 2 даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг тогтоож олгосон байна.
7. Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өрийг барагдуулах талаар өмнө нь байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа хүсэлт гаргасан 22 ажил олгогч байгууллагын 1,237,326,674.79 төгрөгийн гэрээг 6 хүртэл сарын хугацаагаар нэг удаа сунган одоогийн байдлаар 167,671,929.69 төгрөгийн барагдуулан ажиллаа.
8. Итгэлцлийн аяныг AI-аар танилцуулсан бичлэг (Хандалтын тоо – 3.1K)



Итгэлцлийн аяныг танилцуулсан бичлэг /3.1k хандалтын тоо/

9. Аяны хугацаанд нийт 75 ажил олгогчид тус газрын хурлын танхимд Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах, ажил олгогч даатгуулагчдыг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдөр танхимаар сургалт зохион байгуулан ажиллаа. Тус сургалтад UBS телевизээр аяны мэдээллийг танилцуулан сурталчилан хамтран ажилласан болно. /Хандалтын тоо 4,3K /

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН



10. Аяны хугацаанд тус газарт бүртгэлтэй томоохон ажил олгогч байгуулагуудад Нийгмийн даатгалын багц хууль болон даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах чиглэлээр сургалт зохион байгуулан зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа. Макс групп, Ази фарм мед, Зорчигч тээвэр-5, ДЦС-4.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН



САЙН ДУРЫН ДААТГАЛ:

2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” зорилтын хүрээнд хууль тогтоомжийн шинэчлэлийг сурталчилах, иргэд даатгуулагчидад сайн дурын даатгалын ач холбогдолыг таниулах, шинээр хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

- ✓ Сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2025.01.02-2025.12.31-ний хооронд Мандах их сургууль, Байгаль эх цогцолбор, Таван эрдэнэ зах, Баянгол дүүргийн 9, 10, 11, 12, 13, 14, 21, 22, 23, 34 дүгээр хороодоор тус тус ажиллаж зөвлөгөө мэдээллийг давхардсан тоогоор 550-600 хүнд хүргэсэн үүнээс шинээр 205 даатгуулагч хамруулав.
- ✓ Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхтэй холбоотойгоор, Сайн дурын даатгалын 2025 оны жилийн эцсийн төлөвлөгөөгөөр 21,388,308.0 мян.төгрөг төвлөрүүлэхээс жилийн эцсийн байдлаар 17,129,805.1 мянга төгрөг буюу 80,1% төвлөрүүлсэн байна. Үүнээс энгийн сайн дурын даатгалд 16,074,486.6 мянган төгрөг, 0-3 хүртлэх насны хүүхэдээ асарч буй эхийн хөнгөлттэй сайн дурын даатгалд 974,622.4 мянган төгрөг, малчин болон туслах малчны сайн дурын даатгалд 5,691.4 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхийн сайн дурын даатгалд 75,004.7 мянган төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.
- ✓ 2024 онд шинээр нэвтэрсэн <https://portal.ndaatgal.mn/> болон гар утасны апп-р сайн дурын даатгалын шинэ гэрээ хийх, сунгалт, шимтгэл шалгах, төлөлт хийх тухай иргэд даатгуулагчидад цаг тухай бүрт мэдээлэл зөвлөгөө хүргэж ажиллав.
- ✓ Мөн дотооддоо тэтгэвр тэтгэмжийн хэлтэсээс ажилгүйдлийн тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт гаргасан даатгуулагчдийн мэдээллийг авч сайн дурын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулсан.
- ✓ Калл про үйлчилгээг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор тус газрын “72001289-3” дугаарт даатгуулагчдаас ирсэн асуудлыг цаг тухай бүрт шийдвэрлэж, иргэд даатгуулагчидад чирэгдэл учруулахгүйгээр утсаар гэрээ байгуулан, мэдээлэл зөвлөгөө өгч хамрагдалтыг нэмэгдүүлэн ажилласан.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

- ✓ Газрын албан ёсны фэйсбүүк пэйж хуудсаар иргэд, даатгуулагчдад энгийн ойлгомжтой хэлбэрээр постер бэлтгэж дүүргийн хандалт ихтэй пэйж хуудсуудад түгээсэн.

2025 оны 01 дүгээр сарын 01-нээс СИКОС программ нэвтрүүлэн ажилласнаас хойш сайн дурын даатгалын шинээр даатгуулсан болон гэрээ сунгалт хийлгэсэн нийт 13895 гаруй даатгуулагчийн мэдээллийг программд бүртгэснээс 2296 даатгуулагчийг сайн дурын даатгалд шинээр хамруулж нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж ажиллав. Үүнд:



5. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА



1.Дотоод сургалт

Байцаагч ажилтнуудын мэргэжил мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тайлант хугацаанд танхимын 25 сургалтыг зохион байгуулан ажилласан: Үүнд”

1. Үндэсний бичиг,
2. Ажлын байран дахь стресс, түүнийг даван туулах арга зам,
3. Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага,
4. Нурууны суулт түүнээс урьдчилан сэргийлэх,
5. AI /Хиймэл оюун ухаан/ хэрхэн ашиглах, албан хэрэгцээнд хослуулан ашиглах нь,
6. SICOS программын шинэчлэл, түүний хэрэглээ,
7. Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх,
8. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам,
9. Авлига, авлигын шалтгаан, хор хөнөөл,
10. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан гаргах
11. Ажлын байрны стресс
12. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, тэтгэврийн тусгай зохицуулалт, тэтгэвэр бодох аргачлал
13. Стресс түүнээс хэрхэн сэргийлэх арга зам
14. Улсын байцаагчын шалгалтын зөвлөгөө анхаарах зүйлс
15. Долоо хоног бүрийн 4 дэх өдөр “Мэдээллийн цаг” зохион байгуулан ажилтан албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх сэдвүүдээр тус тус танхимын сургалт зохион байгуулан нийт албан хаагчдыг хамруулан ажиллалаа.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН



Гадаад сургалт

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд дэвшүүлсэн “Даатгуулагчдыг дэмжих, Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” зорилтын хүрээнд нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, түүний дотроос иргэд, даатгуулагчдын хамгийн их сонирхсон тэтгэврийн хуулийн шинэчлэл, одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийг сурталчилж, дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

1. Хүннү мебель, Мандах их сургууль,
2. ОСНААУГ ХҮТ-9,
3. ОСНААУГ Хэрэглэгчдэд үйлчлэх төв
4. УБТЗ-н “ЗОРЧИГЧИЙН ВАГОН ДЕПО”,
5. УБТЗ-н “ТАТАХ ХЭСЭГ”,
6. “ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАЦ” ТӨХК,
7. “ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ТАВ” ОНӨААТҮГ,
8. “АЗИ ФАРМА МЕД” ХХК,
9. “МАКС ГРУПП”,
10. “ҮНДЭСНИЙ ТЕХНИКИЙН ИХ СУРГУУЛЬ” зэрэг байгууллагуудад сургалт зохион байгуулан ажилласан.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН



Явуулын үйлчилгээ, нээлттэй хаалганы өдөрлөг

1. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн төвтэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, дэмжих, хамтран ажиллах” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 23–ны өдөр зохион байгуулан ажилласан. Тус өдөрлөгт 500 орчим иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.
2. 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Баянгол дүүргээс “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аян-2025” өдөрлөгийг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд тус газраас “Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” сэдвээр илтгэл тавьж, хууль тогтоомжийг сурталчлан, мэдээлэл хүргэж оролцсон.
3. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр “Нийгмийн хамгаалал” сэдвийн хүрээнд зохион байгуулсан сургалтад тус газраас Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, тэгш хүртээмжтэй нийгмийн даатгалын үйлчилгээг хүнд сурталгүй хурдан шуурхай хүргэх, Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжуудыг сурталчлах зорилгоор дүүргийн Хүүхэд, гэр бүл, хамгааллын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, 34 хороодын Засаг дарга, ажлын алба, хорооны нийгмийн ажилтан нарт мэдээлэл хүргэн, асуусан асуултад хариулт өгч, санал солилцон хамтран ажилласан.
4. Монгол улсын Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дахин магадлалыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 09/19 дугаар удирдамжийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 18-27-ны өдрүүдэд Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд дахин магадлал хийгдсэн. Тус ажлын хүрээнд гарсан дүгнэлт, зөвлөмжийг Эрүүл мэндийн төвийн эмч, удирдлагуудад танилцуулж цаашид авах арга хэмжээний талаар зөвшилцөн, сургалт зохион байгуулсан.
5. Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газраас “Ахмад настныг дэмжих, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” сэдэвт арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 20, 21, 27, 28, 10 дугаар сарын 04-ний өдрүүдэд зохион байгуулсан. Нийт 5 удаагийн арга хэмжээнд 34 хороодын 1500 гаруй ахмад настан хамрагдсан бөгөөд тус арга хэмжээнд “Нийгмийн даатгалын шинэчилсэн хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль” сэдвээр сургалт орж, асуултад хариулан мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.
6. “Итгэлцлийн аян”-ны хүрээнд нийт 75 ажил олгогчийн захирал, санхүүгийн ажилтан, хүний нөөцийн мэргэжилтэнүүдэд тус газрын хурлын танхимд Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах, ажил олгогч даатгуулагчдыг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

2025 оны 10 дугаар сарын 1-ний өдөр танхимаар сургалт зохион байгуулан ажилласан.

7. Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос "ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИЖ, НИЙГМИЙН ШУДАРГА ЁСЫГ ХАНГУУЛЪЯ" уриан дор үйлдвэрчний эвлэлийн хороон дарга, идэвхтэн, сонгуульт ажилтаны улсын анхдугаар зөвлөгөөнийг 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан тус арга хэмжээнд оролцож 150 иргэд, даатгуулагчдад салбарын хууль тогтоомжийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН



6.ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛ

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь 10 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Тус зөвлөлд төрөлжсөн мэргэжлийн дотор, мэдрэл, мэс заслын эмч болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл дүүргийн Эрүүл мэндийн төв, Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн оролцож, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавин, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн ажиллаж байна.



Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай” 01 албан даалгаврын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Тус газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл Монгол улсын засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоолоор баталсан Дүрэм, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/177 А/433 тоот хамтарсан тушаал үндэслэн 2024 оны 12 дугаар сарын 09-ний байдлаар хөдөлмөрийн чадвар түр алдалт болон жирэмсэн амаржсаны тэтгэмжийг цаг алдалгүй хянаж иргэд датгуулагчдад хүргэж байна. Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/441 А/192 тоот хамтарсан тушаалыг үндэслэн 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар Эрүүл Мэндийн Магадлалын Зөвлөл нь иргэн (даатгуулагч)-ийн бичиг баримтад үндэслэн 41 удаа хуралдан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, сунгаж, цуцалж шийдвэрэлснээс 526 иргэнд шинээр тогтоож, 2004 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгаж, 300 иргэнийг цуцалж, шилжиж явсан 3 иргэн, шилжиж ирсэн 15 иргэн, нас барсан 4 иргэн байна.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

ЭММЗ-ийн мэдээллийн сангийн мэдээлэлд дотоод хяналт хийсэн. ЭММЗ-ийн мэдээллийн сангийн мэдээлэлд дотоод хяналт хийсэн, үзлэг хийх шаардлагатай байгаа зарим иргэдийг биеэр ирүүлж байна.

Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг биеэр болон баримт бичигт үндэслэн шийдвэрлэхдээ үзлэг, шинжилгээ, явцын хяналтын байдал зэргийг шалган шаардлага хангасан иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож, сунгаж ажиллаж байна. Шаардлага хангаагүй иргэдийг цуцалж, буцааж хяналтад байх буюу шаардлагатай шинжилгээг 3-р шатлалд хийлгэж ирсний дараа шийдэж ажиллаж байна.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэхэд тогтмол хяналт тавьж, нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон иргэдийн мэдээллийг зөвлөлийн мэдээллийн сантай тулган нас барсан, шилжиж явсан, өвчний ангилал буруу сонгосон, ажилласан жилийн мэдээлэл зөрүүтэй, нэр буруу, регистр буруу зэрэг 6 даатгуулагч, хүний мэдээллийг залруулсан.

Дүүргийн эрүүл мэндийн төв болон 34 хорооны өрхийн эмнэлэгүүдтэй хамтран ажилладаг бөгөөд хөдөлмөрийн чадвар алдалт гэмтэл, мэдрэлийн өвчнөөр тогтоолгосон иргэдийн сэргээн засах эмчилгээг Уламжлалт эмчилгээний тасаг, сэргээн засах тасагт эмчлүүлэх цагийг зохицуулах арга хэмжээ авч ажиллаж байна. Урьдчилан сэргийлэх сургалтыг Монгол улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоолоор баталсан Дүрэм, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/177 А/433 тоот хамтарсан тушаал бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Улсын 3-р төв эмнэлэг, Төмөр замын эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв болон 34 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хууль журмыг танилцуулан сургалтуудыг тасралтгүй зохион байгуулсан.

Үр дүн: 39 байгууллагын давхардсан тоогоор 286 эмч, эмнэлэгийн ажилтныг мэдээлэл арга зүйгээр ханган, 39 удаагийн зөвлөгөө чиглэлийг хүргүүлэн ажилласан.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 18-27-ны хооронд Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд дахин магадлал хийсэн. Дахин магадлалд 298 иргэний эрүүл мэндийн хяналтын картад үнэлгээ хийв. Үүнээс:

- чих, хамар хоолойн өвчтэй 47,
- сүрьеэ өвчтэй 36,
- мэдрэлийн өвчтэй 28,
- дотрын өвчнөөр 185,
- нүдний өвчнөөр 2

тус тус иргэд, даатгуулагчдын картад дахин магадлал хийж дахин магадлалаар хангалттай сайн гэсэн үнэлгээ авсан.

Мөн дүүргийн сонингийн нэг нүүрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зөвөлгөө, тусламж, өгөх булан болгохоор ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны Ажлын хариуцлага, сахилага, дэг журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай 01 тоот албан даалгавар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны Чиглэл хүргүүлэх тухай №01/1136 тоот албан бичиг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны №01/1244 тоот албан бичиг, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 2025 оны Чиглэл хүргүүлэх тухай №09/12 тоот бичиг, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн №09/77 тоот албан бичгийн дагуу тайлангуудыг эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд албан бичгийн хамт хүргүүлсэн.


Монгол улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоолоор баталсан Дүрэм, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/177 А/433 тоот хамтарсан тушаалын хэрэгжилт, Тус дүүргийн 5562 иргэн /даатгуулагч/-н хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн даатгуулагчийн эрхийг хамгаалах, хангахын тулд мэдээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг бий болгох, Монгол улсын Нийгмийн даатгалын тухай багц хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний талаар санал аван ажилласан. Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газар, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтарч ажилласан.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН





Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт болон магадлалын үйл ажиллагаанд оролцогч эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар, хариуцлага, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах зорилгоор нийслэлийн 6 дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн ижил мэргэжилтний үзлэгийг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 14 цагт Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын хурлын танхимд зохион байгууллаа. Уг арга хэмжээнд тус дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн Магадлагч эмч, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэжлийн 3 эмч, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй баг очиж оролцсон.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт харъяалагддаг Эрүүл мэндийн байгууллагуудад Монгол улсын засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоолоор баталсан Дүрэм, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/177 А/433 тоот хамтарсан тушаал, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/441 А/192 тоот хамтарсан тушаалын хавсралтаар Хөдөлмөрийн чадвар алдалтаар эмнэлгийн хуудас бичиж, олгох журмаар сургалт хийсэн. Сургалтад Улсын 3-р эмнэлэг, Эх нялхасын эрүүл мэндийн үндэсний төвийн дүн бүртгэгч эмч, Төмөр замын эмнэлгийн эмч нар, Эрүүл мэндийн 7-р төвийн нарийн мэргэжлийн эмч нар, 34 өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар оролцсон.



Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс зохион байгуулсан дахин магадлалын мөрөөр хийж гүйцэтгэсэн ажлыг хянах, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаатай танилцан, гишүүдийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн №09/94 дугаартай удирдамжийн дагуу Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд гүйцэтгэлийн хяналт хийх зорилгоор тус зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хуралд Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн магадлагч эмч Д.Анхбаяр, Д.Тэмүүжин нар оролцож мэргэжил, аргазүйгээр ханган, гүйцэтгэлийн хяналтыг хийв.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН



Тус хуралд зөвлөл нь бүрэн бүрэлдэхүүнээрээ ирц 90 хувь \мэс заслын эмч өвчтэй\ оролцсон бөгөөд нийт 86 даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэсэнээс 14 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 55 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгаж, 8 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж шийдвэрлэсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Баянгол дүүрэгт зохион байгуулсан дахин магадлалаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, цаашид авах арга хэмжээний талаар хүргүүлсэн санал бүрийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлуудад гүйцэтгэлийн хяналтыг дараах байдлаар зохион байгуулав. Үүнд:

1. Эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллахаар талаар Эрүүл мэндийн 7-р төвтэй хамтран ажиллахаар 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр албан бичиг өгч дүүргийн эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмч нар болон өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нартай хамтран ажиллаж алдаа, зөрчлийг арилган ажиллаж байна.
2. Эрүүл мэндийн байгууллагын эмч нар нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэсэн үндсэн оношийн баталгаажилт болж буй эмчийн үзлэгийн тэмдэглэл, багажийн шинжилгээг эмчийн тэмдгээр баталгаажуулж хэвших ажлын эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн эмч нар болон өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт сургалт зохион байгуулан ажиллаж хэвшсэн.
3. Чих, хамар, хоолойн өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгож, сунгуулж буй нийт даатгуулагч, хүнийг “ASSR” объектив сонсголын шинжилгээнд бүрэн хамруулан шийдвэрлэж байна.
4. Үндэслэлгүйгээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгасан Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд, чих, хамар, хоолойн төрөлжсөн мэргэшлийн эмчээр нийгмийн даатгалын санд учруулсан 3,949,316 төгрөгийн хохирлыг Улсын байцаагчийн актаар нөхөн барагдуулсан.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

5. Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дахин магадлалаар цуцлахаар шийдвэрлэсэн нэр бүхий 8 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг 2024 оны 03 дугаар сарын 05-ны хурлаар цуцалж шийдвэрлэсэн.



Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн 2025 оны өдрийн №01/1044 дугаартай дугаартай удирдамжийн дагуу “Эрүүл мэндийн магадлалын шинэчлэл” сэдэвт Эрдэм шинжилгээний бага хурлын удирдамжийн дагуу Баянгол дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдрэлийн эмч Э.Алтанзаяатай хамтран Баянгол дүүргийн хүн амын дундах тархины харвалтын шалтгаант хөдөлмөрийн чадвар алдалтын өнөөгийн байдал сэдэвтэй илтгэлээр амжилттай оролцсон.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс гаргасан 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн №09/2081 дугаартай чиглэлийн дагуу гадаад улсад амьдарч байгаа иргэдийн судалгааг хороогоор нь ахин гаргаж хяналтын өрхийн эмч нартай хамтран ар гэртэй нь холбогдож өвчний картад нь нарийн мэргэжлийн эмч нартай хамтран хяналт үнэлгээг хийсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/241 тушаалын дагуу Эмнэлгийн хуудас хянан баталгаажуулах, үйл ажиллагаа сайжруулах зорилгоор магадлагч эмч нарын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор эрх нэгтгэж аймаг дүүргүүдийг 5, 5-аар баг болгон хамтран ажиллаж байна.

Үүний үр дүнд ажлын ачаалал буурч мөн иргэдийн гомдол гарахгүй тухайн ирсэн өдрөө эмнэлгийн хуудас хянагдаж өндөр үр дүнтэй байна.

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

Эрүүл мэндийн магадлалын төв комиссоос зохион байгуулсан 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн №09/2441 удирдамжийн дагуу Дундговь аймагтай ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулсан. Дундговийн эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөс иргэн /даатгуулагч/-н 2 картад ижил мэргэжилтний үнэлгээ хийж 1 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцлах шийдвэр гаргасан.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР